



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар #28

Ханх сум

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, 40.3, 40.4, аймгийн Засаг даргын 2024 оны 01-р сарын 24-ны өдрийн А/26 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг тухайн өвчний тархвар зүй, голомтын судалгаанд үндэслэн 2024 оны 05-р сарын 10-ны өдрөөс эхлэн 2024 оны 09-р сарын 15-ны хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг технологит хугацаанд чанартай зохион байгуулахыг "Мундрага" Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эзэн, малын эмч Б.Баясгалан, Тураг 1-р багийн Засаг дарга Ш.Отгонжаргал, 2-р багийн Засаг дарга бөгөөд Турт 3-р багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхжаргал, Баясгалант 4-р багийн Засаг дарга Б.Бямбабаяр нарт, дархлаажуулалт хийх үед товлосон хугацаанд малаа бэлэн байлгаж бүрэн хамруулах, малаа барьж бэхлэн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж малын эмчийн аюулгүй байдлыг хангаж хамтран ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийг ажлын 3 өдөрт багтаан гаргуулан өгч, шийдвэрийг мэдэгдсэн талаарх баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч (П.Баярчимэг)-т даалгасугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг дээрх хугацаанд технологийн дагуу бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж, удирдлага, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Э.Алтангэрэл)-д үүрэг болгосугай

ДАРГА

Л.ДАВААБАЯР

